



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

**Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын сонгуулийн тойрог байгуулж,
мандатын тоо тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.4.2 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, Аймаг, Нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1, 12.4 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XIII хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 10 тойрог байгуулж, тойрогт ногдох мандатын тоо, дугаар, харьяалах нутаг дэвсгэрийн төвийг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолыг Нийслэлийн сонгуулийн хороонд хүргүүлж, нийтэд зарлан мэдээлэх ажлыг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (П.Баянбаатар), Засаг даргын Тамгын газар (Ж.Лхагвасүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

1150100037

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны
өдрийн 3-дугаар тогтоолын хавсралт

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны сонгуулийн тойрог, харьяалах нутаг дэвсгэр,
мандатын тоо

Д/д	Тойргийн дугаар	Харьяалах нутаг дэвсгэр	Мандатын тоо
1	1	1, 3, 4 дүгээр хороо	3
2	2	2, 5, 6 дугаар хороо	3
3	3	7, 8, 20 дугаар хороо	4
4	4	9, 10 дугаар хороо	3
5	5	11, 13 дугаар хороо	3
6	6	12, 21 дүгээр хороо	3
7	7	14, 15 дугаар хороо	4
8	8	16, 22 дугаар хороо	4
9	9	17, 23 дугаар хороо	4
10	10	18, 19, 24 дүгээр хороо	4